

САНХҮҮ-ЭДИЙН ЗАСГИЙН
ТЕХНИКУМЫН
ТҮҮХЭН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

УЛААНБААТАР—1974

ГАРЧИГ

1. Θмнөх уг	3
2. Гаалийн түр сургууль (1934—1935 он)	4
3. Санхүүгийн техникум (1935—1946 он)	9
4. Санхүү-эдийн засгийн техникум (1946—1974 он)	15
5. 50 дахь хичээлийн жилд	21
6. Хавсралт	28

Редактор Б. Гончигсүрэн

Техник редактор Т. Тогтох
Хянач Д. Сайн-Амгалан

Өрөлтөнд 1974 оны 5-р сарын 18-нд
Хэвлэлтэнд 1974 оны 5-р сарын 19-нд
шилжүүлж 2500 ширхэг хэвлэв. Цаасны
хэмжээ 84Х108/32.

Х. х 1.0 Хн. н. х. 1.68
Хэв Газ № Зах № 173

Улсын Хэвлэлийн комбинатад
хэвлэв.
Улаанбаатар Сүхбаатарын
талбай 2.

ӨМНӨХ ҮГ

Октябрыйн социалист их хувьсгал, монголын хөдөлмөрчин олон түмний эрх чөлөөний тэмцлийн зам мөрийг гийгүүлэн заасан билээ.

Хүн төрөлхтний туухэнд шинэ эрин үеийг нээсэн октябрыйн социалист их хувьсгалын шууд нөлөөгөөр МАХН-аараа удирдуулсан монголын ард түмэн пролетарийн хувьсгал ялсан аихны орны ард түмний ах дүүгийн тусламжтайгаар гадаад дотоодын дарлагчдын эсрэг тэмцэлд эрслэн босож 1921 онд ардын хувьсгалыг хийж улс орноо капиталист биш замаар хөгжүүлэн социализмд шилжих нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Хувьсгалаар хуучин феодалын төрийг түлхэн унагааж, ардын эрхт төрийг тунхагласны дараа МАХН, Монголын ард түмний өмнө хувьсгалыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, нийгэм эдийн засгийн гүнзгий өөрчлөлт хийх их зорилт зүй ёсоор тулгарчээ.

1924 онд хуралдсан Намын III их хурал, улс орныг капиталист биш замаар хөгжүүлэх явдлыг намын жанжин шугам болгон баталж түмний хэрэгээс хоцорч, дэлхийн боловсролоос гээгдсэн, феодалын хоцрогдсон монгол орон нийгмийн хөгжлийн бүхэл бүтэн шатыг алгасан хүн төрөлхтний гэрэлт ирээдүй социалист хөгжлийн замд орох их зорилтыг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Ардын хувьсгалыг гүнзгийрүүлэн хөгжүүлж хувьсгалт ардчилсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд МАХН, Ардын төрийн бодлогод чин үнэчүүндэсний шинэ залуу хувьсгалч сэхээтнийг бэлтгэн гаргах явдал зайлшгүй шаардагдаж байв.

МАХН, төрөөс нийгэм эдийн засгийн талаар авч явуулсан олон талт арга хэмжээнүүдийн нэг нь улс ардын аж ахуй, соёлын байгууллагуудад ажиллагсадыг бэлтгэх түр курсууд болон тусгай дунд мэргэжлийн сургуулиудыг нээж хичээллүүлсэн явдал юм.

Тэр тусгай мэргэжлийн дунд сургуулиудын нэг болох санхүү эдийн засгийн техникүм хагас зууц жилийн түүхт замыг туулахдаа БНМАУ-д эдийн засаг, санхүү-бүртгэлийн ажилтны бүхэл бүтэн үеийг сургаж бэлтгэх үйлсэд хүндэтгэй гавьяа байгуулж чухал үүрэг гүйцэтгэжээ.

Техникиумын суурь нь анх гаалийн түр сургуулиар тавигдаж улмаар санхүүгийн техникүм, санхүү-эдийн засгийн техникүм болтдоо өргөжин хөгжиж ирсэн байна.

ГААЛИЙН ТҮР СУРГУУЛЬ

1924—1935 он

МАХН, Ардын засгийн газар, хувьсгалын анхны жилүүдэд нийгмийн амьдралыг арчилж феодалын засаг захиргааг өөрчлөн ардын төрийн үндэс болсон ардын Бүгд Найрамдах засгийг тунхаглан явуулах, хувьсгалаар улс төрийн эрх мэдлээ алдсан феодал ангийн эдийн засгийн хүчин чадлыг эвдэж, улмаар тэднийг английн хувьд устгах, сүм хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэх, гадаадын капиталыг шахан гаргах ардын аж ахуйтны таваарлаг чанарыг дэмжин хөгжүүлж, шинээр төрж байсан хөрөнгөтний элементийг хавчин хязгаарлах, улс орны эдийн засгийн тусгаар тогтолцолыг олж шинэ эдийн засаг соёлыг үүсгэн хөгжүүлэх зэрэг зорилтуудыг шийдвэрлэх талаар чухал арга хэмжээнүүд авч явуулж байв.

Ардын засгийн газар 1922—1924 онд хамжлагат ёсыг халж, феодалын албан татварыг устгаж, гадаадын пүүсүүдэд төлөх өрийг хүчингүй болгов. 1924 онд БНМАУ-ын экспортын 86 хувь, импортын 87 хувь нь Хятад, Америк, Английн 500 гаруй пүүс дэлгүүрүүдэд ноогдож тус орны эдийн засагт гадаадын капиталын нөлөө хүчтэй хөвөэрээ байлаа.

Энэ үед гадаадын капиталыг хавчин хязгаарлаж, улмаар улс орны зах зээлээс шахан гаргах ардын төрийн шинэ албан татвар, гаалийн хэргийг үүсгэн улсын санхүүгийн эх, үндсийг бий болгон арвижуулах талаар МАХН, Ардын төр чухал арга хэмжээнүүд авч явуулж байв.

Нам, засгийн энэ шийдвэрийг хэрэгжүүлэхэд санхүүбүртгэл эдийн засгийн мэргэжилтэй боловсон хүчин ихэд дутагдаж байлаа.

1923 оны 7-р сард хуралдсан Монголын Ардын Намын 2-р их хурал гаалийн ажлыг цаашид сайжруулах асуудлыг авч хэлэлцээд, гаалийн газар, бараа зүйлийг

шалган үзэх буюу хадгалах байр савыг нэмж барих, гаалийн албан хаагчдын орон тоог бүриээр нь ажиллуулах, гаалийн ажилчдын түр сургууль байгуулж мэдлэг мэргэжилтэй хүмүүсийг бэлтгэх нь чухал болохыг заажээ. Намын их хурлын энэ заалтын дагуу 1924 оны 6-р сард засгийн газрын шийдвэрээр Сангийн яамны дэргэд гаалийн нягтлан бодохын түр сургуулийг 40 сургач, 2 багштайгаар байгуулснаар Санхүү-эдийн засгийн техникикумын үндэс суурь тавигджээ.¹

Гаалийн түр сургууль байгуулсан явдал нь тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан санхүү бүртгэлийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх талаар нам засгаас авсан анхны арга хэмжээний нэг байв. Тэр үед гаалийн түр сургуульд суралцах бичиг үсэг бүхий хүмүүс дутагдаж байсныг харгалзан бичиг үсэг мэдэх зарим ноёд залан занги лам нарыг ч хүртэл аймаг хошуудаас нэр цохон ирүүлж суралцуулж байжээ.

Аймаг хошуудаас тохоон дуудсан ноёд түшмэдүүдийн олонхи нь ардын төрийн хэрэгт оролцооос татгалзаж өөрсдийнхөө оронд бичиг үсэг төсөөлөх ядуу ардын хүүхдийг явуулдаг байжээ.

1925 онд хичээллэсэн нэг курсийн бүрэлдэхүүнийг судлан үзвэл хошууны жинхэнэ ноён 2, уе залгамжлах угсаатан 10, лам 1, харц ардын хүүхэд 15 байсны дотор цэцэрлэг мандал аймгийн занги Балжиням, захирагч Пүрэвжав нарын оронд малчин ардын хүү Н. Найдансүрэн, Н. Доохүү нар ирж суралцаж байв. Тэд курсээ амжилттай төгсөж гаалийн хороодод хуваарилагдан ажилласан тэр цагаас хойш санхүү-бүртгэлийн ажлыг тасралтгүй үргэлжлүүлэн хийж ирсэн байна.

МАХН, Ардын төрийн бодлого шийдвэрт дургүйцсэн феодал түшмэдүүд амин хувийн ашиг завшаан хичээж хятадын зальхай худалдаачдын хээл хахууль, бэлэг сэлтэд шунаж, гаалийн татварыг хагас дутуу хураах буюу хураасан заримыг нь хувьдаа ашиглах тэдэнтэй нэгдэн, тал засаж гааль татвараас хэтрүүлэх зэргээр гаалийн хууль дүрэм зөрчиж байхад, гаалийн сургууль төгссөн малчин ардын хүүхдүүд гаалийн татвараар дамжуулан гадаадын мөлжимтгий худалдаачдыг хавчин хязгаарлаж улмаар улсын орлогыг арвижуулах нам

¹ Санхүү-эдийн засгийн техникикумын архивчлан хадгалагдаж байгаа материалд үзэх үү.

засгийн бодлогыг биелүүлэх талаар ихээхэн идэвх чармайлт гарган ажиллаж байсан байна.

Намын 3-р их хуралд Сангийн Яамнаас оруулсан илтгэлд гаалийн хорооны албан хаагчдын дотор аливаа дүрэм хэмжээ худалдааны хэрэг явдал, бараа зүйлийг танин мэдэх боловсон хүмүүсгүй байна.

Гаалийн хороодын албан хаагчид нь автономит үед ч ховдог шунахай, ашиглах этгээд маш олон гэж хэзээ ямагт уг шүүмжлэл гарч байсан бөгөөд ардын засгийн газар байгуулагдсанас хойш аливаа дүрэм хэмжээт тогтоож, боловсронгуй хүмүүсийг оруулсан боловч төдий л сайжирч чадахгүй байна. Иймд гаалийн албанад намын боловсронгуй гишүүдийг томилон ажиллуулах нь зүйтэй гэж тэмдэглэжээ.¹

МАХН. Ардын засгийн газар гаалийн боловсон хүчнийг бэлтгэх гаалийн сургуулийг өргөтгэн бэхжүүлэх талаар байнга анхаарч нам улсын удаа дараагийн их бага, хурлуудаасаа тодорхой удирдамж заалт өгч байсан байна.

1924 оны 6-р сарын 1-нд анхныхаа хонхыг дуугаргаж 40 хүнтэй хичээллэж байсан түр сургуулийг төгсөгчид нь БИМАУ-ыг хөрөнгөтний биш замаар хөгжүүлэхэд саад тогтор болж байсан гадаадын капиталыг шахан зайлцуулж улсын төсвийн орлогыг өсгөн нэмэгдүүлэх, ардын төрийн албан татвар гаалийн бодлогыг хэрэгжүүлэхэд багагүй үүрэг гүйцэтгэжээ.

Гаалийн сургуулийг анх 30 гаруй хүн төгсгөж Алтанбулаг, Улиастай, Ховд, Улаангом, Баянтүмэн, Сулинхээр, Тонхил нуур, Үенч буданч, Базархүйтэнгийн гаалийн хороодод хуваарилагдан ажилласан байна. Гаалийн түр сургуулийн анхны төгсгөгчдийн нэг Базархүйтэн-гаалийн нягтлан бодогчоор ажиллаж байсан Б. Чойнодон одоо эсэн мэнд аж төрж байна.

Гаалийн түр сургууль байгууллагдаж, түүнийг төгссөн ардын үр хувгүүд гаальд ажиллахаас өмнө буюу 1924 онд тус улсын гаалийн орлого 251 мянган янчаан байсан бол 1925 оны эхний хагас жилд I сая 700 мянган янчаан болж өсөн нэмэгджээ.

МАХН-ын 3-р их хурал болон Улсын анхдугаар их хурлын шийдвэр ёсоор 1925 оноос эхлэн дотоодын гаа-

¹ Намын их бага хурал, Төв Хорооны бүгд хурлуудын тогтоол шийдвэр УБ 1956 он I дэвтэр 68—69-р талд үзнэ үү.

лийг аажмаар хорогдуулж 1926 онд монголчуудын худалдаанаас дотоодын гааль хурааж байсан журмыг өөрчилсөн нь аймаг хошуу, хот хөдөөгийн хоорондын эдийн засаг, худалдааны харилцааг өргөтгөхөд чухал нөлөө үзүүлжээ.

1928 онд гадаадын гаалийг өөрчилж бараа зүйлийн үйин 6 хувийг гаальд хураадаг байсныг 9—30 хувь болтол нэмэгдүүлэхийч хамт гаалийн түр сургуулийн үзэх хичээлийг улам боловсронгуй болгож, монгол хэл бичиг, сампингийн 4 арга заадаг байснаа жин хэмжүүрийн нэгж, гаалийн шинэ заавар дүрэм зэрэг хичээлүүдийг нэмж оруулахын зэрэгцээгээр дүн бүртгэл хөтлөх, мэдээ тайлан гаргах журам дүрмийг заах болсон байна. Тэр үед багшлах боловсон хүчин ихээхэн дутагдалтай байсан учир Сангийн яамны баялгийг бадруулах хэлтэст түшмэдийн албан хааж байсан Мэндбаярыг гаалийн сургуулийн захирад багшаар томилж байжээ. Мөн гаалийн сургуульд гааль татвар хураах, бүртгэл, тайлан гаргах, журам зэргийг зөвлөлтийн мэргэжилтэн нараар заалгаж байсны гадна Сангийн яамны гаалийн хэлтсийн тэргүүн зэргийн нягтлан бодох түшмэд Түмэн (БНМАУ-ын Гавьяат багш, доцент)-г томилон ажиллуулж байсан байна.

1925 онд ЗХУ-ын тусламжтайгаар үндэсний мөнгөн тэмдэгтийг бий болгож гүйлгээнд гаргасан нь гадаадын худалдааны капиталд ноцтой цохилт боллоо. 1926—1927 онд Арлын засгийн газар улсын санхүүгийн системийг эмхлэн шэгцлэж улсын төсвийн нэгдсэн системийг тогтоож 1929—1932 онуудад феодалын хөрөнгийг хурааснаар тэд эдийн засгийн үлээмж давуу хүч чадлаа алдан гадаадын капиталтай нэгдэн сүлбэлдэх бололцоогүй болжээ. Гүүнчлэн 1927 онд ардын харилцан туслалцах хоршоог Монголын эд хэрэглэгчдийн хоршоо болгон өөрчилж 1929 онд Монгол Зөвлөлтийн хоорондын худалдааны харилцааны үндсэн зарчмын тухай хэлэлцээрт гарын үсэг зурж улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэхэд чухал шаардлагатай бүх машин тоног төхөөрөмж өргөн хэрэгцээний барааг ЗХУ-ас нийлүүлэх, Монголын түүхий эдийн үнийг ЗХУ дэлхийн зах зээлийн үзээс таван хувь дээгүүр үнээр авч байхаар тохиролцсон байна.

1930 онд импорт экспортыг гүйлгээний ихэнх хувийг

Зөвлөлт Холбоот Улстай хийх худалдаа эзлэх болж, мөн онд гадаад худалдааны улсын онц эрх тогтоогджээ.

Улс орны эдчийн засагт гарсан дээрхи өөрчлөлтүүд болон гадаадыг худалдаачид шахагдан зайлцууллагдсантай холбогдох 1931 оноос эхлэн гаалийн хороод түүний салбаруудын тоог цөөрүүлж тэдгээрийн эрхэлж байсан зарим асуудлыг аймгуудын санхүүгийн хэлтэст хариуцуулах болжээ. Мөн энэ үеэс эхлэн гаалийн түр сургуулийг өргөтгөн нягтлан бодохын түр сургууль болгон хичээллүүлэх болсон байна. 1930 онд хуралдсан улсын 6-р их хурал, газрын баялгийн орлого, бас цахилгаан шуудан, сангийн аж ахуйн орлогыг нэмэгдүүлэх зэрэг улсын эдийн засаг, соёлын ажил өргөжиж орон нутгийн орлого зарлага өсчээ. Иймээс банкны үндсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, банкны хэлтэс салбарыг улсын худалдааны төвүүдэд олшруулах хэрэгтэй. Үүнтэй холбогдуулан Сангийн яам болон Банкны албан хаагчдыг чанаржуулан сайжруулж итгэлтэй хүмүүсээр бэхжүүлэхийн тулд санхүүгийн албан хаагчдыг бэлтгэх явдлыг үргэлжлүүлэн өргөтгөж банк ба санхүүгийн сургуулийг нэгтгэн зохих хүмүүсийг бэлтгэж сургах үүрдийн нэгдсэн санхүүгийн жинхэнэ сургууль болгосугай¹ гэж заажээ.

1929—1930 оны хичээлийн жилээс эхлэн нягтлан бодохын түр сургуулийг 2 жилийн хугацаатай болгож сурагчдын тоо, заах хичээлийн хүрээг өргөтгөн хичээлийн төлөвлөгөө, программыг сангийн яамны коллегоор батлуулан ажилладаг болжээ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлт 1933 онд санхүү зээлийн системийг шинэчлэх шийдвэр гаргаж, зээл, тооцооны ажиллагааг өөрчилж банкны зээлийн тодорхой нэр төрөл заасан баталгаатай төлөх тодорхой хугацаатай болгож зээл ашиглалт ба олголтыг аж ахуйн газрын төлөвлөгөөний биелэлттэй нягт уялдуулан холбож зээлийн үйл ажиллагаанд шинэ зарчим нэвтрүүлж эхлэв. Үүний үр дүнд гүйлгээнд гаргах мөнгөний тоо хорогдох, зүүний нугалаа завхралын үед эрс алдагдсан мөнгөний гүйлгээ эрүүлжиж бүртгэл тооцоо цэгцэрснээс гадна жилийн тайлан балансыг бүх газрууд гаргадаг болсон байна.

¹ БНМАУ-ын их бага хурлуудын тогтоол, үндсэн хууль түнхагууд 1956 он УБ 170 дахь тал.

Нам төрөөс авч явуулсан удаа дараагийн арга хэмжээний нь дүнд тус сургуулийн багш, сурагчдын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж багш нарын тоо 3 дахин, нийт сурагчдын тоо 1,8 дахин төгсөгчид нь 1,5 дахин тус тус өссөн байна.¹

Гаалийн түр сургууль болон нягтлан бодохын түр сургууль нь 1935 он хүртэл II жилийн турш хичээллэхдээс эх орондоо бүртгэл тооцооны мэргэжилтэн 420 гаруй боловсон хүчинийг бэлтгэж гаргасан байна.²

САНХҮҮГИЙН ТЕХНИКУМ

1935—1946 он

Ардчилсан хувьсгал гүнзгийрэн хөгжих явцад үндэсний аж үйлдвэр тээвэр, харилцаа холбоо худалдааны байгууллагууд үүсэн бий болж санхүү зээлийн систем тогтох сангийн аж ахуй, өвс хадах станц зэрэг шинэ шинэ аж ахуйн салбарууд байгуулагдан социалист аж ахуйн хэвшил бүрэлдэж тогтох байсан явдал нь бүртгэл тооцооны мэргэжилтэй боловсон хүчинийг улам ихээр шаардах болов. Энэ байдлыг харгалзан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл 1935 оны 8-р сард нягтлан бодохын сургуулийг өргөтгөн өөрчилж санхүүгийн техникимыг байгуулах шийдвэр гаргажээ.³

Үүний зэрэгцээгээр нам ба улсын сургуулийн бүрэлдэхүүнд хичээллэж байсан худалдааны нягтлан бодох, бараа түүхий эдийн мэргэжилтэн бэлтгэх сургуулийг нэгтгэн элсэх сурагчдын тоог нь 150 хүртэл олшуруулж бага, дунд сургуулийн 4,5-р анги төгсөгчдийг элсүүлэх болсон боловч элсэгчид хүрэлцээгүй байснаас бичиг


¹ Санхүү-эдийн засгийн техникумын архивчлан хадгалагдаж байгаа материалыас үзнэ үү.

² Мөн тэнд

³ БНМАУ-ын бага хурлын тэргүүлэгчид ба Сайд нарын Зөвлөлийн хууль, тушаалуудыг эмхтгэн хавсаргасан сэтгүүл 1935 он № 80(3) 473-р хуудас

Үсэг мэдэх хүмүүсийг элсүүлэн бэлтгэл анги болгон хичээллүүлж байжээ.

Сургуульд суралцагчид олширч анги танхим хүрэлцээгүй болсон учир тус сургуульд цэргийн эмнэлгийн хуучин байрыг шилжүүлэн өгчээ. Мөн сургуулийн сургалтын төлөвлөгөө программыг шинэчлэн боловсруулж үзэх хичээлийг нь олшруулан ерөнхий эрдмийн талаар газар зүй, түмэн бодис, түүх, улс төрийн хичээл тусгай



1935 онд Санхүү эдийн засгийн техникум гэж нэрлэгдэн Цэргийн эмнэлэгээс шилжүүлэн авсан хичээлийн байр

мэргэжлийн талаар нягтлан бодохын онол, нийтийн нягтлан бодох, салбарын нягтлан бодох, банк худалдааны нягтлан бодох, улсын санхүүгийн орлого зарлагын бүртгэл, балансын шинжилгээ төлөвлөгөө, тоо бүртгэл зэрэг хичээлийг нэмэн заах болж сургалтын чанар агуулгыг нь сайжруулж үзэх зүйлийн хүрээг нэмэгдүүлэн материалыг баазаар нь бэхжүүлэх талаар нилээд арга хэмжээ авав.

Сургуулийн багшлах, мэргэжлийн боловсон хүчнийг чанаржуулах талаар ч нам засгаас чухал арга хэмжээ авч дээд боловсролтой багш нарыг томилон ажиллуулах болжээ.

1938 онд ЗХУ-д дээд сургууль төгсөж ирсэн нөхөр Ю. Цэдэнбалыг (МАХН-ын Төв Хорооны 1-р нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга) Сангийн яамны сайдын тушаалаар тус техникумын хичээлийн эрхлэгч бөгөөд балансын шинжилгээ, банкны хэрэг заах багшаар ажиллуулсан байна.

Ю. Цэдэнбалыг хичээлийн эрхлэгчээр томилсон Сангийн Яамны сайдын тушаалд н. Цэдэнбал нь идэвх зүтгэл тэсвэр хатуужилтай суралцаж амжилттай төгсөж ирснийг сайшаан тэмдэглээд тус техникумын хичээл хүмүүжлийн ажлыг сайжруулахад ихээхэн амжилт гаргаж чадна гэдэг итгэл төгс байгаагаа илэрхийлжээ.

Мөн техникумыг 1931 онд төгсөж Дорноговь аймгийн Санхүүгийн хэлтсийн даргаар ажиллаж байсан Сономын Лувсанг (МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1-р орлогч дарга) 1938 онд санхүүгийн техникумын захибраар томилжээ.

Тус сургуулийн удирдах болон багшлах боловсон хүчиний талаар нам засгаас авсан байнгын анхаарал хамжийн үр дунд багш нарынх нь мэргэжил боловсрол, сурган хүмүүжүүлэх дадлага чадвар жилээс жилд өсөж залуу боловсон хүчиний этнээ өргөжин заах арга барил нь дээшилж ирсэн байна.

Сургууль орос хэл сайн мэдэх багш нартай болж, чухал шаардлагатай сурах бичиг ном зохиолуудыг орос хэлнээс орчуулж хэрэглэх болсноос гадна багш нар заах арга барилдаа Зөвлөлт Холбоот Улсын багш нарын туршлагыг өргөн хэрэглэж эхэлсэн нь сурагчдын сурлагын хүмүүжлийн ажлыг цаашид сайжруулахад ихээхэн нөлөө үзүүлжээ.

1938 оныг 1936 онтой зэрэгцүүлэхэд тус сургуулийн онц сурлагатны тоо 30 хүнээр нэмэгдэж сурлагын нийт амжилт 3,8%-иар өссөн байна.¹


1939 онд хуралдсан улсын 22-р бага хурлаас нөхөр Ю. Цэдэнбалыг Сангийн яамны дэд сайдаар баталжээ.

Ю. Цэдэнбалыг Сангийн яамны дэд сайдаар томилогдон ажиллах болсонтой холбогдуулж хийсэн санхүүгийн техникумын багш ажилчдын цуглаанаас БНМАУ-ын бага хурлын тэргүүлэгчид болон БНМАУ-ын

¹ Санхүү-эдийн засгийн техникумын архивчлан хадгалж байгаа материалыас үзнэ үү.

Ерөнхий сайдад илэрхийлсэн талархалдаа «манай ардын дотроос шинээр төрж гарсан бөгөөд Маркс-Лениний бодит онол сургаалаар биээ зэвсэглэсэн үнэнч шудрага залуу шинэ үүчин болох нөхөр Цэдэнбалыг манай удирдлагад дэвшүүлэн тохоон сонгосон явдалд бид нараас маш их баярлаж, хувьсгалын халуун баяр хүргэе»¹ гэж тэмдэглэсэн байна.

Нөхөр Ю. Цэдэнбал тус сургуулийн хичээлийн эрхлэгч байхдаа сургуулийн сургалт хүмүүжил, зохион байгуулалтын ажлыг дээшлүүлэх талаар ихэд анхаарал тавьж байжээ.



Сурагчдын байр. (1935 он)

Нөхөр Ю. Цэдэнбал өөрийн хариуцаж байсан хичээлийн эрхлэгчийн ажлыг Зөвлөлт Холбоот Улсад Худалдааны эдийн засгийн дээд сургууль төгссөн Б. Тагарт хүлээлгэн өгчээ. БНМАУ-ын гавьяат багш Тагар энэ ажлыг 20 гаруй жил идэвх зүтгэл үр бүтээлтэй хийж 1959 оноос нягтлан бодох бүртгэлийн оройн дээд сургуулийн захирлаар шилжин ажилласан байна. Нөхөр С. Лувсан 1940 онд Сангийн яамны сайдаар дэвшин

¹ Санхүү-эдийн засгийн техникиумын архивчлан хадгалагдаж байгаа материалд үзнэ уу.

ажилласан учраас Завхан аймгийн санхүүгийн хэлтсийн дарга байсан Ч. Зул Санхүүгийн техникумын захирлаар ажиллах болжээ. Ч. Зул санхүүгийн техникумын захирлын ажлыг 1953 он хүртэл 12 жил тасралтгүй хийж дараа нь Барилгын яамны орлогч сайдаар дэвшиин ажиллажээ.

1938—1939 оны хичээлийн жилээс эхлэн тус техникумд казак хүүхдүүдийг элсүүлж казак хэлний тусгай бэлтгэл анги нээж хичээллүүлэв. Энэ бэлтгэл ангид суралцагчдын нэг нь одоо Намын дээд сургуульд багшилж байгаа эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн У. Камбар юм.

МАХН-ын удирдлага, Монголын ард түмний шургуу тэмцэл хөдөлмөрийн үр дүнд Хувьсгалын ардчилсан шатны төгсгөлд манай орны улс төр, эдийн засгийн амьдралд гүн гүнзгий өөрчлөлтүүд гарав.

1940 онд хуралдсан МАХН-ын 10-р их хурал тус орны эдийн засгийн хоцрогдол болон хүмүүсийн ухамсар дахь феодализмын үлдэгдэлтэй тэмцэх, ардын аж ахуйтны хувийн санаачлагыг өрнүүлэх улс ардын аж ахуйн социалист секторыг бэхжүүлэн, нэгдсэн төлөвлөгөөг нэвтрүүлэх үндсэн дээр үйлдвэрлэх хүчинийг бүхий л талаар хөгжүүлж ард түмний тасралтгүй өсөж байгаа материал соёлын хэмжээг байнга дээшлүүлэх заалт өгөв.

Нам засгийн энэ түүхт шийдвэрийг биелүүлэхэд юуны урьд улс ардын аж ахуйд ажиллах эдийн засгийн ондөр боловсролтой боловсон хүчин бэлтгэх явдал зүй ёсоор шаардагдаж байв. Иймд тус техникумд онцрайн дүнтэй суралцаж байсан сурагч Д. Моломжамц Б. Дүгэrsурэн, Г. Минжуур, Л. Занабазар, У. Камбар, Ж. Цэрэн-янжин, О. Цэнд нарыг 1940—1941 онуудад Иркутск хотын эдийн засгийн дээд сургуульд явуулсан суралцуулжээ. Эдгээр сурагчид Зөвлөлт эх орны их дайны хүнд бэрх үед тэсвэр хатуужил идэвх зүтгэлтэй суралцаж сургуулиа амжилттай төгсгөөд Д. Моломжамц Сангийн яамны жинхэнэ орлогч сайдаар, Занабазар, Минжуур, Цэрэн-янжин нар уул техникумдаа багшаар ирж ажилласан байна. Тэр үед ЗХУ-ын төрөл бүрийн сургуульд Монголын 739 оюутан суралцаж байв.

Нам засгаас санхүүгийн техникумыг бэхжүүлэх талаар удаа дараа авч явуулсан арга хэмжээний үр дүнд материаллаг бааз нь бэхжиж улс ардын аж ахуйн сал-

барт эдийн засгийн дунд мэргэжилтэй нягтлан бодогч нарыг олон тоогоор бэлтгэн гаргав. Техникумыг төгссөн боловсон хүчинүүд бүртгэл дансны ажлыг сайжруулж, санхүүгийн шинэ эх үүсвэрлийг нээж олох, социалист өмч хөрөнгийг үр бүтээлтэй ашиглах түүнд тавих хяналт шалгалтыг сайжруулан үндэсний орлогыг нэмэгдүүлэх явдал болон үйлдвэр хөдөө аж ахуй, соёл гэгээрлийг хөгжүүлэн улс орныг батлан хамгаалах үйлст чухал үүргийг гүйцэтгэсэн байна.

Тус техникум 1935—1946 он хүртэлх 11 жилийн дотор санхүү-бүртгэлийн дунд мэргэжилтэй 500 шахам хүнийг төгсгөн гаргаж нийт сурагчдын тоо нь 1924 оны хоос 50,4 дахин, багш нарынх нь 10 дахин, төгсөгчид нь 1,4 дахин өсчээ.¹ Фашист Герман Зөвлөлт Холбоот Улсад итгэлийг эвдэн довтолсон эх орны их дайны жилүүдэд ах дүү Зөвлөлтийн ард түмний тусlamжтайгаар БНМАУ-ын үйлдвэр хөдөө аж ахуй өсөн хөгжсөөр байлаа.

Өөрийн орны дотоодын нөөц баялгийг аль болохоор дүүрэн ашиглаж үйлдвэрийг хөгжүүлэх үндсэн дээр ЗХУ-аас авч байсан бараа таваарын хэмжээг багасгах явдал нь дайны хүнд хүчрийг туулж байгаа Зөвлөлтийн ард түмэнд ах дүү монголын ард түмнээс үзүүлэх тусlamж дэмжлэгийн нэг байв.

Улс орны дотоод нөөц баялгийг ашиглаж үндэсний үйлдвэрийг өргөтгөн хөгжүүлэхэд зориулж зөвхөн улсын төсвөөс оруулсан хөрөнгө, 1942—1945 онуудад 27,9 сая төгрөг болжээ. Үүний үр дүнд үндэсний аж үйлдвэрийн бүтээгдэхүүн жил дараалан нэмэгдсээр байв. Тус улсын 1945 оны нийт үйлдвэрийн бүтээгдэхүүнийг 1940 онтой зэрэгцүүлэхэд 2 илүү дахин өсчээ.²

Дайны хүнд бэрх жилүүдэд улсын санхүүгийн ажлыг улам нарийсган, санхүүгийн хяналт шалгалтын аппаратыг төв орон нутагт байгуулж, улсын төсвийч орлого зарлага бий дараалан нэмэгдсээр байв. Энэ үед улс ардын аж ахуйн төлөвлөгөөний биелэлтийг үнэн зөв тодорхойлох, аж ахуй санхүүг нарийн чанд тооцож, улс хоршооллын өмч хөрөнгийг хайрлан хамгаалах ажлыг хүчтэй болгох, аж

¹ Санхүү-эдийн засгийн техникумын архивчлан хадгалагдаж байгаа материалд үзнэ үү

² БНМАУ-ын түүх 3-р боть 1969 он 459—464-р тал.

ахуйн тооцоо нягтлан бодох бүртгэлийг хөнгөн шуурхай нарийн тодорхой байлгах явдал хурцаар тавигдаж байснаас нягтлан бодогч нарын эрх үүрэг хариуцлагыг нилээд өргөтгөжээ.

БНМАУ-ын хөгжил цэцэглэлт ялангуяа эдийн засгийн хөгжил нь санхүү-бүртгэл эдийн засгийн мэргэжил бүхий үндэсний боловсон хүчин бэлтгэх ажлын чанарыг цаашид дээшлүүлэх тэдгээрийн мэргэжил боловсролын хүрээг өргөтгөх, төгсөгчдийг олшуруулах явдлыг чухлаар шаардаж байсан учир бүртгэл эдийн засгийн дунд мэргэжилтнийг бэлтгэх үндсэн уурхай болсон санхүүгийн техникумын зохион байгуулалтыг өргөтгөн өөрчлөх шаардлага нэгэн адил тавигджээ.

САНХҮҮ-ЭДИЙН ЗАСГИЙН ТЕХНИКУМ

1946—1974 он

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1946 оны 8-р сарын 9-ны өдрийн 49-р тогтоолоор санхүүгийн техникумыг санхүү-эдийн засгийн техникум болгон өөрчилж, суралцах хугацааг 3 жил болгон төгсгөгчдийг 3 жил цэргийн албанаас чөлөөлөн зохих мэргэжил дээр нь тогтвэр сууршилтай ажиллуулж байхаар шийдвэрлэсэн байна.

Техникум 1946—1947 оны хичээлийн жилээс эхлэн санхүү, төсөв, банк, үйлдвэр, барилга, сангийн аж ахуйн нягтлан бодох бүртгэл, төлөвлөгөө тоо бүртгэл, хяналт шалгалтын дунд мэргэжилтнийг бэлтгэх, үндсэн ангиудтай болж сургалтын төлөвлөгөөгөөр МАХН-ын түүх, бүх холбоотын эв хамт большевикуудын намын түүх, БНМАУ-ын түүх, ХАА-н үндэс, цэрэгжил, биений тамир, хими физикийн хичээлүүдийг нэмж заах болжээ.

Тус техникумын сургалт, эдийн засгийн дунд мэргэжилтэн бэлтгэх ажил үлсын хөгжлийн үе шат, нам засгийн гадаад дотоод бодлого шинжлэх ухаан техникийн дэвшил, тус орны эдийн засгийн хөгжилттэй холбогдон

ийнхүү шинэчлэгдэн өөрчлөгдж боловсрон сайжирсаар иржээ.

1946 онд Санхүү-эдийн засгийн техникумд суралцагсын тоог 375 болгож нэмэгдүүлжээ. Суралцагсынх нь too өсөж байгаатай холбогдуулж тус техникиумыг онцсайн дүнтэй төгссөн авьяас чадвар бүхий сурагчдыг сургуульд нь багшаар үлдээж ажиллуулах болсон байна.

Сургуулиа онцсайн дүнтэй төгсгөж багшаар үлдсэн Ю.Балжиниам, Ж.Галсансанжаа нар одоо хүртэл тус сургуульдаа багшилсаар байна.

Тус техникумд узэх «нягтлан бодохын үндэс» гэдэг анхны сурах бичгийг Зөвлөлтийн мэргэжилтэн А. А. Юрков багш Ч. Түмэн нар 1949 онд хамтран зохиосон байна. Түүнээс хойш аж үйлдвэрийн нягтлан бодох бүртгэл, аж үйлдвэрийн газрын аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээ, зэрэг олон ном сурах бичгүүд зохиогдож гарсан нь санхүү-эдийн засгийн дунд мэргэжилтэн бэлтгэхэд чухал аж холбогдолтой болов.

1947 оны 12-р сард хуралдсан МАХН-ын 11-р их хурал монголын ард түмэн МАХН-ынхаа удирдлагаар дэлхийн хоёрдугаар дайны хүнд бэрхийг даван туулж энх тайван бүтээн байгуулалтанд шилжин орсныг тэмдэглээд улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөөний удирдамжийг батлан гаргав.

Анхдугаар таван жилийн төлөвлөгөөгөөр намаас өгсөн удирдамжийн дагуу малын too толгойг олшууллах, морин өртөөг авто өртөөгөөр солих, үйлдвэр сургууль эмнэлгийн газруудыг өргөтгэн мэргэжилтэй боловсон хүчинээр хангах, бүх нийтийг бичиг үсэгт сургах зэрэг арга хэмжээг биелүүлэхэд төрөл бүрийн мэргэжил бүхий боловсон хүчний нэгэн адил тус техникиумын бэлтгэн гаргах бүртгэл тооцооны мэргэжилтэй боловсон хүчинүүд ч чухал үүрэг гүйцэтгэх нь мэдээж байв.


Анхдугаар таван жилд Санхүү-эдийн засгийн техникиумын анги бүлгийн тоог 1948 оныхоос 1,7 дахин нийт сурагчдынх нь тоог 1,8 дахин, төгсөн гаргагчдыг 6 дахин нэмэгдүүлэх байлаа.

1952 он буюу таван жилийн төлөвлөгөөний эцэст анги бүлгийн too 1,8 дахин, төгсгөгчид 8 дахин өссөн боловч улс ардын аж ахуй соёлын салбарт эдийн засгийн дунд мэргэжилтэй хүмүүс хүрэлцээгүй хэвээр л байв.

Техникум, Намын Төв Хороо Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор 1949 оноос эхлэн аж үйлдвэр, сангийн аж ахуй, гар үйлдвэрийн газруудын болон төсвийн нягтлан бодогч нарыг богино хугацааны курсээр бэлтгэх үүрэг авч 1952 он хүртэл 1300 шахам нягтлан бодогч нарыг бэлтгэн гаргасан байна.

Санхүү-эдийн засгийн дунд мэргэжилтнийг бэлтгэх үүргийг амжилттай биелүүлж байгааг нь нам засгаас өндөр үнэлж Санхүү-эдийн засгийн техникумыг 1944. 1946 онуудад Засгийн Газрын Хүндэт Үнэмлэхээр, 1949 онд Хөдөлмөрийн Гавьяяны Улаан Тугийн Одонгоор тус тус шагнажээ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1953 оны 5-р сарын 15-ны өдрийн 182-р тогтоолоор тус техникумын хичээл сургалт зохион байгуулалтыг өөрчлөн техникумд 7-р анги төгсгөгчдийг элсүүлэн ерөнхий эрдмийн талаар бүрэн дунд боловсролтой тусгай мэргэжлийн талаар эдийн засгийн дунд мэргэжилтэн бэлтгэхээр зохион байгуулан суралцах хугацаанд нь сар бүр 180—250 төгрөгийн стипенди, онц сайн сурлагатанд 15%-ийн нэмэгдэл олгож байх, түр курст 3 жилээс доошгүй бүртгэл тооцооны ажил хийж байсан хүмүүсийг элсүүлэхээр заажээ.



Санхүү-эдийн засгийн техникумын хичээлийн байр.
(1956 он)

Нам засгийн эдгээр арга хэмжээний үр дунд сургалтын нь чанар сайжирч хичээлийнх нь хүрээ өргөсөн техникумыг төгсгөгчид нь мэргэжлийнхээ дагуу гадаад, дооодын дээд сургуульд элсэж суралцах бүрэн бэлтгэлтэй болсоор сурагчдын идэвх сонирхол улам дээшилж мэргэжил дээрээ тогтворт суурьшилтай ажиллах явдал сайжирсан байна. Түүнчлэн техникумын багшлах боловсон хүчний тоо өсөж боловсролын хэмжээ нь ихээхэн дээшлэн 1953 онд бүх нарын 70% нь бүрэн ба бүрэн бус дээд боловсролтой болжээ.

Техникум 1956 онд 30 гаруй анги танхим уншлагын ба хурлын заал, ерөнхий боловсролын дунд сургуулийн 9, 10-р антиудад хэрэглэгдэх хими физикийн хичээлийн кабинет бүхий хичээлийн байртай болжээ.

Мөн 1961 онд биений тамирын заал, 1962 онд 300 сурагчид суух дотуур байртай болж сургууль материаллаг базын хувьд бүрэн бэхжсэн байна.

Нам засгаас хувийн аж ахуйтныг хоршооллох талаар авсан олон талт арга хэмжээний үр дунд энэ хөдөлгөөн идэвхтэй өрнөж байсан 1950-аад оны дунд үеэс ардын үйлдвэрлэлийн нэгдлийн нягтлан бодогч нарыг бэлтгэх чухал үүргийг тус техникум хүлээн авч ардын үйлдвэрлэлийн нэгдлийн нягтлан бодохын ангийг шинээр нээж хөдөө аж ахуйн нягтлан бодогч нарыг улс хоршооллын аж ахуйн чиглэлүүдээр жил тутам бэлтгэн гаргаж байв.

Хөдөө аж ахуйн нэгдлийн нийгмийн аж ахуйг өсгөн бэхжүүлж нэгдэлд төлөвлөгөө зохион байгуулалтыг нэвтрүүлэн, тайлан тооцоотой болгох, хөдөлмөр зохион байгуулалт хөлс олгох журмыг боловсронгуй болгоход тус техникумын бэлтгэсэн санхүү-эдийн засгийн дунд мэргэжилтнүүд зохих хувь нэмрээ оруулсан байна.

Ажилчин албан хаагчдыг үйлдвэрлэлээс хөндийрүүлэхгүйгээр дээд, тусгай дунд боловсрол олгох МАХН-ын 15-р их хурлын заалтын дагуу 1967 оноос тус техникумын дэргэд аж үйлдвэр, төсвийн нягтлан бодогч нарыг бэлтгэх оройн салбар, 1971 оноос хөдөө аж ахуйн нягтлан бодогч нарыг бэлтгэх эчнээ салбар нээгдэн хичээллэв.


Техникум сургалтын төлөвлөгөө заах хичээлийн программаа өргөтгөж улс ардын аж ахуйн хөгжлийн шаардлагын дагуу 1972—1973 оны хичээлийн жилээс эхлэж бүрэн дунд сургууль төгсөгчдийг элсүүлэн суралцах ху-

гацааг 2 жил болгон түр курсын сургалтыг мэргэжил олгох ба дээшлүүлэх 45—90 хоногийн хугацаатай болгож нэг хичээлийн жилд 2—4 удаа төгсгөлт хийж байхаар зохион байгуулав.

Санхүү эдийн засгийн дунд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тус техникумын үйл ажиллагаанд Зөвлөлт Холбоот улсаас уригдан ирж ажиллаж байсан мэргэжилтэн, багш нар ихээхэн хувь нэмэрээ оруулсан юм. Анх гаалийн түр сургууль байгуулагдааас эхлэн мэргэжлийн хичээлүүдийг заах, тусгай мэргэжлийн хичээлийн заалт болон заах арга сурган хүмүүжүүлэх ухаанд багш нарыг дагалдуулан сургах сурхадаа бичиг зохиох, улс ардын аж ахуй соёлын хөгжилтийн дагуу техникумын сургалтын агуулга чанарыг боловсронгуй болгон өөрчлөн зохион байгуулж, сургалтын төлөвлөгөө программын уялдаа холбоог тухайн үеийн шаардлагад тохицуулан сайжруулах явдалд ЗХУ-ын мэргэжилтэн багш нарын өдөр тутам үзүүлж байсан тусламж нь хагас зуун жилийн туршид эх орондоо эдийн засгийн дунд мэргэжилтэн бэлтгэн гаргасан Санхүү-эдийн засгийн техникумын түүхтэй салшгүй холбоотой юм. Манай ахмад багш А. А. Юрков 1949 онд нягтлан бодох бүртгэлийн онолын анхны сурхадаа бичгийг зохиолцож, Звенигород хотын санхүү зээлийн техникумын нягтлан бодох бүртгэлийн багш Пухова Валентина Алексеевна 1961—1964 онуудад тус техникумд багшилж байхдаа нягтлан бодохын онол, аж үйлдвэрийн ба бусад салбаруудын нягтлан бодох бүртгэл, аж үйлдвэрийн газрын аж ахуйн үйл ажиллагааны шинжилгээний программ, заах аргуудыг боловсруулж сургалтын төлөвлөгөөг ерөнхий боловсролын сургуулийн 7, 8-р анги төгсөгчдийг хүлээн аваад З жилд бүрэн дунд боловсролтой болгохын зэрэгцээгээр тусгай дунд мэргэжилтэн бэлтгэх явдалд тохицуулан өөрчлөхөд туслалцсан нь эдийн засгийн дунд мэргэжилтэн бэлтгэх ажлыг чанаржуулан сайжруулахад үнэтэй хувь нэмэр болсон юм.

Тус техникум одоо Москва хотын Бүх Холбоотын санхүү зээлийн техникумтай шефийн холбоо тогтоон ажиллаж зохион байгуулалт сургалт хүмүүжлийн баялаг туршлагаас нь суралцсаар байна.

Санхүү-эдийн засгийн техникумыг төгсөгчдийн дотроос нам төрийн зүтгэлтэн, яамдын сайд, тусгай газрын дарга нар эрдэмтэд, зохиолч, урлаг спортын алдар цуу-



Сурагчдын байр. (1962 он)

тан, гавьяат багш, гавьяат эдийн засагчид, дипломатууд санхүү банкны тэргүүний ажилтнууд олон арваараа төрөн гарсан юм.

Техникумыг төгсөгч С. Лувсан одоо МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1-р орлогч даргаар, Д. Моломжамц МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, Намын Төв Хорооны нарийн бичгийн даргаар, Б. Дүгэрсүрэн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч даргаар Д. Содном Улсын Төлөвлөгөөний Комиссийн даргаар, Ц. Молом БНМАУ-ын Сангийн Яамны сайдаар, Е. Очир БНМАУ-ын Гадаад Худалдааны Яамны сайдаар, П. Дамдин БНМАУ-ын Хөнгөн Хүнсний Үйлдвэрийн Яамны сайдаар О. Нямаа БНМАУ-ын Нийтийн Аж Ахуй Үйлчилгээний яамны сайдаар М. Лхамсүрэн БНМАУ-ын Хөдөлмөр Цалин Хөлслний Улсын Хорооны даргаар, П. Төмөр БНМАУ-ын Банкны Ерөнхий Хорооны даргаар ажиллаж байна.

Техникумыг төгссөн олон хүн БНМАУ-ын яамдын орлогч сайд тусгай газрын орлогч дарга, аймаг хотын намын хороод, АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга,

орлогч, нарийн бичгийн дарга, Элчин сайд, олон улсын байгууллагын төлөөлөгч зэрэг хариуцлагатай ажил хийж байна.

БНМАУ-ын Төрийн шагналт яруу найрагч Ц. Гайтав, зохиолч Д. Гармаа, Б. Явуухулан, БНМАУ-ын Ардын жүжигчин Н. Цэвэгмид, БНМАУ-ын Урлагийн гавьяат зүтгэлтэн хөгжмийн зохиолч Мяасүрэн, спортын гавьяат мастер Ж. Мөнхбат нар ч тусгай дунд боловсровлыг эндээс олж авцгаажээ.

Санхүү-эдийн засгийн техникумын хамт олон болон сурган хүмүүжүүлэгчид өөрийнхөө сургуулийг төгссөн тэргүүний шавь нараараа бахархаж, тэдний сурлага, хүмүүжил хөдөлмөрийн амжилтыг залгамж хойч үед нь үлгэр дууриалал болгож байдал юм.

МАХН-ын 16-р их хурлаас сонгогдсон МАХН-ын Төв Хорооны жинхэнэ орлогч гишүүд Төв шалган байцаах комиссын гишүүдийн 1% нь, 1973 онд явагдсан БНМАУ-ын Ардын Их Хурлын 8 дахь удаагийн сонгуулиар сонгогдсон АИХ-ын депутатын 3,8% нь, БНМАУ-ын гавьяат багш нарын 7,4 хувь, Ардын жүжигчдийн 5,8 хувь нь урлагийн гавьяат зүтгэлтний 2,5 хувь нь, төрийн шагналтын 4,1 хувь, спортын гавьяат мастеруудын 5,8 хувь, эдийн засгийн ухааны эрдэмтдийн 14% санхүү банкны тэргүүний ажилтны 50 гаруй хувь нь тус техникиумын ахмад төгсгөгчид байна.

Санхүү-эдийн засгийн техникум үүсч байгуулагдсанаас хойш санхүү бүртгэл эдийн засгийн дунд мэргэжилтэй 10 гаруй мянган боловсон хүчнийг бэлтгэж гаргасан нь улс ардын аж ахуй, соёлын салбаруудад үр бүтээлтэй ажиллаж, нам засгаас өгсөн үүрэг даалгаврыг нэр төртэй биелүүлж байна.

50 ДАХЬ ХИЧЭЭЛИИН ЖИЛД

«Ямар нэгэн нийгмийн байгууллага бол тухайн ангийн санхүүгийн тусламжтайгаар бий болно»¹ гэсэн их

¹ В. И. Ленин зохиолууд 4 дэх удаагийн хэвлэл 33-р боть 473 дахь тал.

Лениний заалтыг үндэс болгосон МАХН, Хувьсгалын жилүүдэд ардын төрийн санхүү эдийн засгийн бүртгэл тооцооны мэргэжилтэн бэлтгэх талаар зүйл бүрийн арга хэмжээ авав.

Хувьсгалын ялалтын үр дүнд байгуулагдсан санхүү эдийн засгийн техникум сургалтын төлөвлөгөө программ нь тогтмолжин хичээлийн материаллаг бааз нь бэхжиж одоо орос хэл, нийгмийн ухаан, нягтлан бодох бүртгэл, биений тамир зэрэг орчин үеийн техник хэрэгслэлээр бүрэн тоноглогдсон 10 гаруй кабинет, 20 гаруй мянган боть номтой номын сан, нэг ээлжинд 80 хүн суух уншлагын заалтай бөгөөд энэ нь жилд дундчаар 2000 шахам уншигчид төрөл бүрийн сурах бичиг, нийгэм улс төр, шинжлэх ухаан техникийн болон уран зохиолын, олон төрлийн тогтмол хэвлэлээр үйлчилж байна.


Бүрэн дээд боловсрол бүхий 60 шахам багш нар заах аргын 4 нэгдэлтэйгээр, 1300 гаруй сургачид өдөр, орой, эчнээ, түр курсээр 38 анги бүлэг болон хичээллэж, үйлдвэр, хөдөө аж ахуй төсөв, банк, барилга тээвэр зэрэг 7 төрлийн нягтлан бодох мэргэжлээр 50 дахь жилдээ хичээллэж байна.

Техникумын сургалт хүмүүжлийн олон талт үйл ажлыг удирдан зохион байгуулах үүргийг захирал, орлогч захирал, хичээлийн эрхлэгч нар заах аргын нэгдлүүдээс бүрэлддэг сургуулийн захиргаа гүйцэтгэхийн зэрэгцээгээр, намын үүр ҮЭ-ийн хороо, МХЗЭ-ийн хороо, сургачдын зөвлөл зэрэг нам олон нийтийн байгууллага ажиллаж байна.

Улс ардын аж ахуй соёлын салбарт эдийн засгийн дунд боловсролтой коммунист хүмүүжилтэй залуу мэргэжилтнийг бэлтгэх үүргийг биелүүлэх талаар нам засгаас тавьсан зорилтыг хэрэгжүүлэх явдалд сургуулийн захиргаа нам олон нийтийн бүх байгууллага багш нарын үйл ажиллагаа чиглэгдэж байна.

Санхүү эдийн засгийн техникумд суралцах сургачдын тоо жил ирэх тутам өсөн нэмэгдэхийн хамт, нам олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагаа идэвхжин өргөжиж ирэв.

Одоо тус сургуулийн сургачдын 99.8 хувь нь залуучуудын эвлэлийн гишүүд байна. Техникумд одоо өсвөрийн залуу үеийг нам ард түмнийхээ хөдөлмөрч баатарлаг дайчин уламжлалаар хүмүүжүүлэх өв тэгш боловсролтой өндөр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд эр-



МОНГОЛ АЛТАЙН НУРУУНЫ ИСЭН ОРГИЛ МӨНХ ХАЙРХАН
УУЛЫН САЛБАР ДАЛАЙН ТӨВШИӨӨС 4026 МЕТР ӨРГӨГДСЕН ЭНЭ
ОРГИЛЫГ 1969 ОНД ТЕХНИКУМЫН АХМАД ТӨГСӨГЧ БЯМБАДОРЖ,
БАТЦАГААН НАР ДӨРВӨН НӨХДИЙН ХАМТ АВИРЧ (САНХҮҮЧ) ГЭЖ НЭРЛЭЖСЭ.

ДЭМ УХААНАА ЗОРИУЛАН ИДЭВХ ЗҮТГЭЛТЭЙ АЖИЛЛАЖ БАЙГАА Г. ДУЛАМДОРЖ, Ж. ЦЭРЭН-ЯНЖИН, Ю. БАЛЖИННЯМ, Ж. ГАЛСАНСАНЖАА НАРЫН ЗЭРЭГ АХМАД БАГШ НАР БОЛОН ШИНЭ ЗАЛУУ БАГШ НАР АЖИЛЛАЖ БАЙНА.

Сургалтын төлөвлөгөөгөөр заагддаг биений тамир хөгжмийн анхны мэдэгдэхүүний хичээлээс гадна хичээлээс гадуур явагддаг биений тамир, спорт, урлаг, уран сайхны 10 гаруй секцэнд олон арван охиц хөвгүүд суралцаж, спорт, урлагийн алдар цуутай гавьяатнууд тэрөн гарсаар байна.


Манай эх орны амьдралд нийгэм эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлт гарч хөдөлмөрчин олон түмний улс төрийн ухамсар соёлч байдлын хэмжээ өдрөөс өдөрт өсөж нөхөр ёсоор харилцан туслаж хамтран ажиллах хөдөлгөөн аж үйлдвэр тээвэр, харилцаа холбоо, хөдөө аж ахуй, соёл гэгээрлийн байгууллагуудын хамт олны дунд өргөн далайцтай өрнөсөөр байна.

Санхүү эдийн засгийн техникумын багш, сурагчид социалист ёсоор сурч аж төрөх өв тэгш зорилтыг өмнөө тавьж 1964 онд Галсанпунцаг ахлагчтай багш нарын


БАГШ СУРАГЧДЫН ТӨГСӨЛТ

1924 он = 1;


Багш нар



Төгсөгчид



Сурагчид



сэхээтний социалист нөхөрлөл Цэрэндондов ахлагчтай сурагчдын соёлч нөхөрлөл анхны цол мандатыг авсаннаас хойш олон бригад жил дараалан төрөн гарсан юм.

Одоо тус техникумын бүх багш ажилчдын 27 хувь чь сэхээтний социалист нөхөрлөл, социалист хөдөлмөрийн төлөө бригадад сурагчид нийтээрээ соёлч нөхөрлөлийн жедэлгөөнд хамрагдан соёлч сургууль болохоор авсан үүргээ амжилттай биелүүлж байна.

БИМАУ—1960-аад оноос хөгжлийнхээ шинэ үед орж социализмын материал техникийн базыг байгуулж дуусгах зорилтыг шийдвэрлэж эхэлсэн нь улс ардын аж ахуй соёлын салбарт ажиллах онолын зохих бэлтгэлтэй, социалист байгуулалтын практиктай танил болсон мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах чухал үүрэг, их дээд, тусгай дунд мэргэжлийн сургуулиудад тавигдсан байна.

1963 оны 2-р сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал «Тусгай мэргэжлийн дээд ба дунд сургуулиудын сургалтыг өөрчлөн сайжруулах үндэс бол хичээлийг үйлдвэрлэлтэй нягт холбох явдал мөн»¹ гэж заасан байна.

Санхүү-эдийн засгийн техникумын багш, сурагчид Хөдөө аж ахуйд ургац хураах малын хашаа барих, бэлчээр усжуулах, хот тохижуулах барилга барих зэрэг социалист бүтээн байгуулалтын ажилд жил бүр идэвхтэй оролцож хичээл сургуулиа үйлдвэрлэлтэй уялдуулан зохиох болсон байна.

1961 онд атар газар эзэмших Зэлтэрийн сангийн аж ахуй байгуулагдсан үеэс эхлэн тус техникум шефийн холбоо тогтоон ажиллаж тулгын чулууг нь тавилцсаанаас хойш ургац хураах, хадлан бордоо авах, хашаа саравч барихад нь 13 жил тасралтгүй туслаж ирэв.

Санхүү-эдийн засгийн техникумын багш, сурагчдын хөдөлмөр бүтээлийг МАХН, төрөөс өндөр үнэлж 1970 онд Засгийн газрын Хүндэт жуух бичгээр З дахь удаагаа шагнажээ. Социализмын материал техникийн базыг амжилттай байгуулж байгаа манай оронд нийгмийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж түүний эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх нь онцгой ач холбогдолтой юм. Орчин үед үйлдвэр, аж ахуйн газрыг биеэ даасан аж ахуйн тооцооны зарчим дээр ажиллуулахад юуны өмнө өндөр

¹ МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлын илтгэл, тогтоол УБ 1963 оны 64-р тал

мэргэжилтэй нягтлан бодогч эдийн засгийн мэргэжилтнийг олноор нь бэлтгэх явдал чухлаар шаардагдаж байна.

МАХН-ын XVI их хурал Төв Хорооны удаа дараагийн бүгд хурлуудын шийдвэрийн дагуу үйлдвэрийг удирдах, төлөвлөх арга барилыг боловсронгуй болгож аж ахуйн тооцоог сайжруулан хамт олны материаллаг сонирхлыг өндөржүүлэн хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор улс ардын аж ахуйн салбарын зарим салбаруудыг төлөвлөлт удирдлагын шинэ системд 1968 оноос эхлэн шилжүүлэв.

Иймд бүртгэл эдийн засгийн дунд мэргэжилтний уурхай болсон тус сургуулийн өмнө нягтлан бодох бүртгэлийн шинэ хуучин системд хослон мэргэжсэн боловсон хүчинийг бэлтгэх чухал зорилт тавигдаж байна.

Улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх талаар на-маас авч байгаа олон талт арга хэмжээний үр дунд, сүүлийн жилүүдэд шинэ шинэ үйлдвэрүүд бий болж байгаагийн зэрэгцээгээр үйлдвэрүүдийн тасаг, цех, ХАА-н бригад, фермүүдийг аж ахуйн тооцоонд оруулан ажиллуулж байгаа нь бүртгэл эдийн засгийн дунд мэргэжилтэн бэлтгэх ажлыг цаашид улам бүр сайжруулах, суралцацад богино хугацаанд их зүйлийг сургах шаардлага тавигдаж байна.

Санхүү-эдийн засгийн техникумын, нам захиргааны байгууллагууд болон багш нар сургалтанд орчин үеийн хэрэгслэлийг аль болохоор хэрэглэж хичээлийн минут бүрийг эрчимтэй ашиглаж сургчдад бүртгэлийн техник хэрэгслэлийг эзэмших практик ажиллагаанд сурх чадвар дадлага олгох хичээлийн үр дүнг дээшлүүлэх сурагчдын бие дааж бүтээлчээр сэтгэн бодох чадвар авьяас билгийг бүх талаар нь хөгжүүлэх зорилгоор картаар бодлого бодуулах хичээлийн явцад тайллан баланс гаргах, хэсэгчилсэн дүн шинжилгээ хийлгэх, салбар тус бүрийн аж ахуйн үйл ажиллагааг бүхэлд нь тусгасан бодлого дасгалуудыг зохиох зэргээр сургалт хүмүүжлийн ажлын шинэ арга хэлбэрүүдийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Орчин үед социалист нөхөрлөлийн орнуудын хэмжээгээр бүртгэлийг өргөн далайцтай механикжуулж байгаа нь бүртгэлийн ажлыг улам хөнгөн шуурхай болгон социализмын үеийн үргэлж өсөн нэмэгдэж байгаа

аж ахуйн асар том үйл ажиллагааг цаг тухайд нь бүртгэн дүгнэх боломжийг олсоор байна.

Манай улсад ч тооцоолон бодох төв байгуулагдан аж ахуйн газруудын бүртгэлд техник хэрэгслэлийг өргөн ашиглах боллоо. Бүртгэлийн өнөөгийн техник хэрэгслэлийг бүрэн эзэмшиж түүний шаардлаганд тохируулан баримт материалыг боловсруулах чадвар эзэмшсэн, МАХН-ын үйл хэрэг, улс эх орныхоо тусын тулд бүх хүч чадлаа дайчлан ажиллах өрнүүн идэвх зүтгэл, өргөн мэдлэг бүхий эдийн засгийн дунд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх явдал санхүү-эдийн засгийн техникумын нэн тэргүүний зорилт болж байна.

Санхүү-эдийн засгийн техникум нь үүсч байгуулагдаасаа хойш 50 жилийн замналыг туулахдаа аж ахуй зохион байгуулалт хичээлийн материаллаг базын хувьд үлэмж бэхжиж улс орондоо санхүү-эдийн засгийн тусгай дунд мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэж өгдөг нэг томоохон тусгай дунд сургууль болтлоо өргөжиж хөгжсөн байна.




БНМАУ-ын Сангийн яамны
сайд Ч. Молом. 1950 оны
төгсөгч



БНМАУ-ын Улсын банкны
ерөнхий хорооны дарга
П. Төмөр. 1952 оны
төгсөгч



Эдийн засгийн хамтын
ажиллагааны олон улсын
Банкны Ерөнхий хорооны
гишүүн, Б. Долгормаа.
1944 оны төгсөгч.



БНМАУ-ын Хөнгөн Хүнсний
Үйлдвэрийн яамны сайд
П. Дамдин. 1950 оны
төгсөгч




БНМАУ-ын Гадаад Худалдааны яамны сайд Е. Очир
1949 оны төгсөгч



БНМАУ-ын Нийтийн Аж
Ахуй Үйлчилгээний яамны
сайд О. Нямаа. 1946 оны
төгсөгч



БНМАУ-ын Хөдөлмөр Цалин
Хөлсний Улсын Хорооны
дарга
М. Лхамсүрэн 1945 оны
төгсөгч



Улсын төлөвлөгөөний комиссийн дарга Д. Содном.
1950 оны төгсөгч



БНМАУ-ын гавьяат эдийн засагч Г. Даанжамц 1936 оны төгсөгч



БНМАУ-ын Гавьяат багш
Б. Дэжидмаа



Сангийн яамны орлогч
сайд П. Сосорбарам.
1950 оны төгсөгч



БНМАУ-ын Гавьяат багш
Доцент Ч. Түмэн.




БНМАУ-ын Гавьяат багш
Б. Тагар



Гаалийн цягтлан бодохын
түр сургуулийн анхны захирал
Ч. Мэндбаяр



Ч. Зул. 1940—1952 онуудад
захирал байсан




Санхүү эдийн засгийн
техникиумын ахмад багш
ЗХУ-ын мэргэжилтэн



Увс аймгийн АДХ-ын
Гүйцэтгэх захирагааны дарга
Г. Баасанжав 1952 оны
төгсөгч



Сангийн Яамны орлогч сайд
Ч. Өнөнди. 1955 оны төгсөгч
А. А. Юрков.



1924 оны ахинь төгсөгч
Базархүйтэнгийн гаалийн
няягтлан бодох байсан
Б. Чойидон.

